

Батлав:

“ӨСВӨРИЙН ЗОХИОН БҮТЭЭГЧ-2024” ҮЗЭСГЭЛЭНГИЙН УДИРДАМЖ

Зорилго:

❖ Хүүхдийн шинжлэх ухаанч мэдлэг, чадварыг нь нэмэгдүүлэх, өөрсдийн сонирхлоор хамт олонтойгоо туршилт судалгаа хийхийг дэмжиж зохион бүтээх авьяас чадварыг хөгжүүлэх

❖ Ирээдүйн мэргэжил сонголтоо хийхэд нь дэмжлэг үзүүлэх туршилт бүхий оюуны бүтээлүүдийг шалгаруулж, урамшуулах, шилдэг бүтээлүүдийг сурталчлахад зорино

Санаачилан зохион байгуулагч: Монголын зохион бүтээгчдийн нэгдсэн холбоо

Дэмжигч зохион байгуулагч:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар
- Эдийн засаг хөгжлийн яам
- Боловсролын яам
- Монголын нисэх загварчдын МАСА нийгэмлэг
- Авто загварчдын холбоо ТББ

Хамтран зохион байгуулагч:

- Боловсролын ерөнхий газар
- Хүүхдийн урлан бүтээх төв
- Дэмжигч байгууллагууд

Хамрах хүрээ: Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн Ахлах, дунд, ангийн сурагчид оролцоно.

Тавигдах шалгуур:

- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд, ангид суралцдаг байх;
- Багаар, анги хамт олноороо болон бие даан оролцох, баг нь 2 ба түүнээс дээш гишүүнтэй байх ба баг өөр өөр сургуулийн сурагчдаас бүрдэж болно. Энэ тохиолдолд аль нэг гишүүнийхээ харьяа сургуулиас оролцох;
- Шинэ санаа, шийдэл агуулсан, техник технологийн дэвшилд тулгуурласан, гэр, сургуулийн орчинд хийгдсэн, судалгаа, туршилттай байх;
- Бүтээл нь хүний өдөр тутмын амьдралд хэрэглэгддэг, хөдөлмөр үйл ажиллагаа хөнгөвчилсөн байх;
- Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, үйл ажиллагаа, хичээлээс гадуурх сонгон, секц дугуйлангуудын хөтөлбөр, агуулгатай нийцсэн техник спортын загварууд
- ЕБС-ийн сурагчдын технологийн хичээл болон сонгон суралцах дугуйлангуудаар хийж бүтээж амжилт гаргасан техник спортын загварууд, хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн ХАА болон хүрээлэн буй орчин байгаль хамгаалах чиглэлээр оновчтой шинэ санал тусгасан эдийн засгийн үр ашигтай, төрөл бүрийн тоног төхөөрөмж багаж техникийн бүтээлүүдийн биет болон макет загварууд зохиож бүтээсэн бүтээл байж болно.

Уралдааны журам:

- Уралдаанд оролцоход үнэ төлбөргүй. Бүртгэлийг сурагч өөрөө, эсвэл багш, эцэг эх, асран хамгаалагч, найз нөхдийн хамтаар хийсэн байх ёстой
- Бусдын ажлыг хуулбарлахыг хориглоно. Оролцогчийн өөрийн санаа, бүтээл байх

Багаар оролцох тохиолдолд:

- Баг нь 2 ба түүнээс дээш гишүүнтэй байна. Анги хамт олноороо оролцож болно.
- Оролцох баг өөр өөр сургуулийн сурагчдаас бүрдэж болно. Тийм тохиолдолд аль нэг гишүүнийхээ харьяа сургуулиас оролцох.

Бүртгэл: 2024.12.12ны өдөр хүртэл / Хүүхдийн Урлан Бүтээх төвд/

- Бүртгүүлэхдээ дараах мэдээллийг оруулна. Үүнд:
- Сургуулийн нэр, хаяг, байршил
- Бие даан оролцож байгаа тохиолдолд сурагчийн нэр, багийн нэр, багийн гишүүдийн нэр, анги бүлгийн нэр, багшийн нэр
- Бүтээлийн нэр
- Уралдаанд оролцоход үнэ төлбөргүй.Бүртгэлийг сурагч өөрөө, эсвэл багш,эцэг эх, асран хамгаалагч, найз нөхдийн хамтаар хийсэн байх ёстой.

Явагдах газар: Монголын хүүхдийн урлан бүтээх төвд

Нээлт: 2024.12.13-ний өдөр 10:00 цагт, / 2024.12.14 өдөр хүртэл /

Холбоо барих утас: 9987-3578, 9917-1398

Цахим шуудангийн хаяг: /mzbnh2020@gmail.com/

Шалгаруулалт: Үзэсгэлэнгийн бүтээлийг зохион байгуулагчдаас бүрдсэн шүүгчдийн бүрэлдэхүүн үнэлж, шалгарсан бүтээлийн эздийг шагнаж, урамшуулна

Шалгаруулалтад дараах зарчмыг баримтална

Үүнд:

- Техник технологийн шийдэл
- Үзэмж дизайн
- Шинэлэг энгийн сонирхолтой санааг тусгасан эсэх

Шагнал урамшуулал:

- ❖ Тэргүүн байр тус бүр 1 /ахлах,дунд анги тус бүр/ нийт 2
- ❖ Дэд байр тус бүр 2 /ахлах, дунд анги тус бүр/ нийт 4
- ❖ Шагналт байр тус бүр 3 /ахлах дунд анги тус бүр/ нийт 6

➤ “Өсвөрийн зохион бүтээгч” алт, мөнгө, хүрэл медалийг дагалдуулж мөнгөн болон дэмжигч байгууллагын, шагнал урамшуулал олгох

➤ Идэвхтэй оролсон сурагч,багшийн ивээн тэтгэгч байгууллагуудын шагналаар шагнах.

**“БҮТЭЭЛЧ ХАМТЫН, ИННОВАЦИ”-Д НЭГДЭЦГЭЭ
МОНГОЛЫН ЗОХИОН БҮТЭЭГЧДИЙН НЭГДСЭН ХОЛБОО**